

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 65.020.40

Үхэр нүдний суулгац. Техникийн шаардлага	MNS 6251 : 2011
Black currant seedlings. Technical requirement	

Стандарчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2011 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор батлав.

Энэ стандартыг улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэнэ мөрдөнө.

Энэхүү стандартын норматив шаардлагыг заавал¹ мөрдөнө.

1. Хамрах ба хэрэглэх хүрээ

1.1 Энэхүү стандарт нь үхэр нүдний суулгац үржүүлэх, бэлтгэн нийлүүлэх чанарыг тогтоох, шалган хүлээн авах, боох, хадгалах, борлуулах, импортлох, тээвэрлэхэд хамаарна.

1.2 Энэ стандартыг баталгаажсан технологийн дагуу үхэр нүдний суулгацыг үржүүлдэг мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэд болон хяналт шалгалтын эрх бүхий байгууллагууд, суулгац худалдан авагчид хэрэглэнэ.

2. Норматив ишлэл

Энэхүү стандартад дараах баримт бичгийг иш татсан бөгөөд эдгээр стандартад өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны материалаас иш татаж хэрэглэнэ.

- MNS 2782:79, Ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүн. Хортон шавьжийг илрүүлэх арга.
- MNS 2783:2005, Ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүн. Мөөгөнцөрийн өвчнийг илрүүлэх арга,
- MNS 2784:2007, Ургамал, ургамлын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн. Бактерийн гаралтай өвчнийг илрүүлэх арга,
- MNS 4722:1999, Шим бордоо. Чийгийн улаан хорхойн биоялзмаг,
- ГОСТ 13853:78, Яст болон үрт жимст модны үр тариалалтын чанар. Техникийн нөхцөл,
- ГОСТ 24835:81, Интоорын тарьц суулгац тариалалтын чанар.

3. Нэр томьёо, тодорхойлолт

3.1 Үхэр нүдний эх цэцэрлэгийн талбай

Үхэр нүдний жимс хурааж авах буюу үржүүлэг хийх зориулалтаар байгуулсан талбай,

3.2 Жимст эх цэцэрлэг

Жимс хурааж авах зориулалтаар байгуулсан талбай дахь цэвэр сортын мод бутны бүлгэмдэл,

¹ Стандарчиллын үндэсний зөвлөлийн 2014 оны 38 дугаар тогтоолоор эрх зүйн хэм хэмжээг “сонгон хэрэглэх” болгон өөрчлөв

MNS 6251 : 2011

3.3 Үржүүлгийн эх цэцэрлэг

Мөчир авах зориулалтаар шигүү тариалсан, цэвэр сортын мод бутны бүлгэмдэл,

3.4 Ургал эрхтний үржүүлэг

Үржүүлгийн эх цэцэрлэгийн мод бутнаас мөчир нугалах болон модлог, ногоон мөчир, нахиа, үндэс зэргийн аль нэг хэсгээс авч үндэслүүлж суулгац гаргах арга,

3.5 Хоёр настай суулгац

Эхний жил үндэслүүлж, дараа жил нь бойжуулгын талбайд дахин тариалж торинуулсан суулгац,

3.6 Модлог мөчрийн суулгац

Үржүүлгийн зориулалттай эх цэцэрлэгээс ургалтын хугацааны нэг жилийн өсөлтийг гүйцээж бүрэн холтосжиж, модожсон мөчрөөр бэлтгэн ургуулсан хоёр настай суулгац,

3.7 Ногоон мөчрийн суулгац

Үржүүлгийн зориулалтын эх цэцэрлэгээс тухайн жилийн өсөлтийн найлзуурыг мананжуулах төхөөрөмжид үндэслүүлж дараа жил нь бойжуулж, торинуулсан хоёр настай суулгац,

3.8 Бойжуулгын талбай

Хүлэмжид үндэслүүлсэн нэг наст тарьцыг суулгац болтол нь ургуулах тусгайлан бэлтгэсэн талбай,

3.9 Механик гэмтэл

Мөчир нахиа хугарч бяцраагүй, үндэс тасраагүй, холтос шалбараагүй байдал,

3.10 Хэвийн чийг

Мөчир, үндэс хорчийж ус чийг алдагдлын шинж ажиглагдаагүй байдал,

3.11 Суулгацын өндөр

Үндэсний хүзүүнээс оройн хэсэг.

4. Ангилал

Үхэр нүдний суулгацыг чанараар нь 1, 2 дугаар зэрэг гэж ангилна.

5. Техникийн шаардлага

5.1 Суулгацыг баталгаажсан технологийг баримтлан үржүүлнэ.

5.2 Үржүүлгийн эх цэцэрлэгт сортын хянан баталгаа хийсэн байна.

5.3 Жимслэх эх цэцэрлэгийг хоёр настай суулгацаар байгуулна.

5.4 Суулгацын шинж чанарын үзүүлэлт 1, 2-р хүснэгтэд заасан шаардлагыг хангасан байна.

5.5 Цэвэр сортын, механик гэмтэлгүй, хортон шавьжид нэрвэгдээгүй, 1-р зэргийн суулгацаар үржүүлгийн талбайг байгуулна.

Суулгацын чанарын үзүүлэлт

1-р хүснэгт

Д/д	Үзүүлэлт	Чанарын шаардлага	
		1-р зэрэг	2-р зэрэг
1.	Үндэсний урт, см	30-50	22-оос доошгүй
2.	Мөчрийн урт, см	40-50	35-аас доошгүй
3.	Мөчрийн тоо, ш	3-4	2-3
4.	Мөчрийн голч, см	0,7-1,0	0,5-0,7

ТАЙЛБАР 1: Үхэр нүдний 2-р зэргийн шаардлагад хүрэхгүй суулгацыг мод үржүүлгийн газрын бойжуулгын талбайд тарина.

ТАЙЛБАР 2: Хадгалалт, тээвэрлэлтийн үед суулгацын нахиа ба холтос нь 10 %-иас хэтрэхгүй механик гэмтэлтэй байхыг зөвшөөрнө.

Морфологи шинжийн үзүүлэлт

2-р хүснэгт

Д/д	Үзүүлэлт	Үзүүлэлт
1.	Үндэсний гадаад байдал	Үндэс өтгөн, харлаж ялзраагүй, хорчийж, хэрчлээ үүсээгүй байна.
2.	Мөчрийн өнгө	Сортын үндсэн өнгийг хадгалсан байна
3.	Мөчир, нахианы гэмтэл	Механик гэмтэл үндсэн салаа мөчрийн гадаргууд 10%-иас ихгүй байж болно.
4.	Үндэс, мөчрийн эрүүл байдал	Хөнөөлт организмд нэрвэгдээгүй

6. Дээж авах

Суулгацын стандартын 1, 2-р хүснэгтэд заасан шинж, чанарыг баримтлан нийт суулгацын 10 %-иас доошгүйг шалгаж хүлээн авна.

7. Шалгах арга

7.1 Суулгацыг хавар тарилт хийхээс өмнө буюу 5-р сарын 1-р арав хоногт, намар тарихын өмнө 10-р сарын 2-р арав хоногт багтаан шалгана.

7.2 Суулгацын урт болон голчийг шугам ба штангенциркулиар хэмжинэ.

7.3 Үхэр нүдний бактер, мөөгөнцөрийн өвчнийг MNS 2784:2007 стандартын дагуу тодорхойлно.

8. Боох, хаяглах, хадгалах, тээвэрлэх

8.1 Суулгацыг 1 сар хүртэлх хугацаагаар хадгалахад суваг татаж суулгацын үндэсний хүзүү хүртэл чийгтэй шороогоор 20-оос 30 см зузаан хучиж, өдөрт 2-оос 3 удаа усалж байвал зохино.

8.2 Салхинаас үндсийг хамгаалан 100 см урт, 60 см өргөн нийлэг хальс, таар шуудайн дээр чийглэсэн үртсийг жигд тараагаад, суулгацын үндсийг шороон зуурмагт хутгаж үзүүрийг нэг тийш нь харуулж тавиад суулгацыг өөр хоорондоо

MNS 6251 : 2011

үрж холхихгүйгээр модны үртэс буюу шороогоор хөдөлгөөнгүй чигжисний дараа үндэсний хэсгийг таараар битүү дугуйлан боосон байна.

8.3 Суулгацыг 50-иас 100 ширхэгээр боож, хаягийг тээвэрлэлтийн үед тасарч гээгдэхээс хамгаалан боодлын гадна ба дотор талд зүүнэ.

а/ Боодлын дотор зүүх хаягийг 7 см урт, 5 см өргөн модон ба зузаан цаасаар хийж дээр нь зөвхөн сортын нэрийг бичнэ.

б/ Боодлын гадна зүүх хаягийг 100 см урт, 8 см өргөн хийж дээр нь сортын нэрийг, тоо ширхэг, зэрэг дугаарын хамт бичнэ. Хаягийг баларч арилахаас хамгаалсан байна.

8.4 Боолттой суулгацанд дараах зүйл бүхий шошго нааж хаяглан тарьж суулгах заавар, зөвлөмжийг дагалдуулна.

- Суулгац үйлдвэрлэгч байгууллага, аж ахуйн нэгжийн нэр,
- Стандартын дугаар,
- Сортын нэр,
- Суулгацын тоо, ширхэг,
- Он, сар, өдөр.

9. Хадгалах

9.1 Мод үржүүлгийн газраас авсан суулгацыг тарих хүртэл түр хугацаагаар хадгалах тохиолдолд суваг татаж, суулгацны үндэсний хэсгийг 15-аас 20 см зузаан чийгтэй шороогоор булж хадгална.

9.2 Намар хүлээж авсан суулгацыг өвөлжүүлэхдээ 30-аас 40 см гүн шанг салхины хөндлөн татаж, уг суулгацыг тэр нутгийн ноёлох салхины зүгийн дагуу налуулж нэг нэгээр эгнүүлэн тавиад үндэсний хэсгийг 30-аас 40 см зузаан шороогоор булж ханатал усалж хадгална.

9.3 Хадгалалтын хугацаанд мэрэгчид суулгацын үндсийг гэмтээхээс хамгаалж гүнзгий шуудуу татаж услах, эргэн тойрон хорт өгөөш тавих, нарийн тороор хаших ба цас ормогц хөрсний гадаргуу дээр ил байгаа суулгацын иш, мөчрийг цасаар нягтруулан дарна.

10. Тээвэрлэх

10.1 Боодолтой суулгацыг бүх төрлийн тээврийн хэрэгслээр тээвэрлэхдээ босоо байдлаар эгнүүлэн тавьж доор нь 10-аас 15 см зузаан зөөлөвчтэй ачих бөгөөд боодлын хоорондох зай завсарт чийгтэй үртэс болон шороогоор чигжиж дүүргэнэ. Хол тээвэрлэх бол үндсийг тогтмол чийглэж хатахаас хамгаална.

10.1 Тээвэрлэлтийн хугацаа 4 хоногоос хэтрэхгүй байна.

ТӨГСӨВ.